МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ СОЦИАЛИСТ ВЬЕТНАМ УЛСЫН ХООРОНД ИРГЭН, ГЭР БҮЛИЙН БОЛОН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ

Г Э Р Э Э

Монгол Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс /цаашид "Хэлэлцэн тохирогч Талууд" гэнэ/ нь бие биеийн бүрэн эрхт байдлыг хүндэтгэх, харилцан адил байх үндсэн дээр эрх зүйн харилцааны салбарт хамтын ажиллагааг хэрэгжүүлэх, иргэн, гэр бүлийн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцааг харилцан үзүүлэх зорилгоор дараахь зүйлийг хэлэлцэн тохиров.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл

Эрх зүйн хамгаалалт

1.Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохирогч негее Талын нутаг дэвсгэр дээр хувийн болон эд хөрөнгийн эрхийн талаар Хэлэлцэн тохирогч негее Талын иргэний нэгэн адил эрх зүйн хамгаалалт эдэлнэ.

2.Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн нь Хэлэлцэн тохирогч негее Талын хуулийн байгууллагад, түүнчлэн иргэн, гэр бүлийн болон эрүүгийн хэргийг авч хэлэлцэх эрх бүхий бусад байгууллагад челеетэй, саадгүй хандах эрхтэй бегеед хүсэлт, нэхэмжлэл гаргаж болохын зэрэгцээ байцаан шийтгэх бусад ажиллагаанд Хэлэлцэн тохирогч негее Талын иргэний нэгэн адил оролцох эрхтэй.

3.Энэхүү Гэрээний заалт нь Хэлэлцэн тохирогч Талуудын хуулийн этгээдэд нэгэн адил хамаарна.

2 дугаар зүйл

Эрх зүйн туслалцаа үзүүлэх

1.Хэлэлцэн тохирогч Талуудын хуулийн байгууллага нь иргэн /худалдаа, хеделмерийнхийг оролцуулаад/, гэр бүлийн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцааг энэхүү Гэрээний заалтын дагуу харилцан үзүүлнэ.

2.Хэлэлцэн тохирогч Талуудын хуулийн байгууллага нь энэ зүйлийн 1-д заасан хэргийг авч хэлэлцэх эрх бүхий бусад байгууллагад эрх зүйн туслалцаа үзүүлнэ.

3 дугаар зүйл
Харилцах журам

1.Хэлэлцэн тохирогч Талуудын хуулийн байгууллага эрх зүйн туслалцаа үзүүлэхдээ тус тусын Төв байгууллагаар дамжуулан харилцаж байна. Үүнд:

Монгол Улсын талаас Монгол Улсын Хууль зүйн яам, Ерөнхий прокурорын газар;

БНСВУ-ын талаас БНСВУ-ын Хууль зүйн яам, Ардын дээд прокурорын газар;

2.Иргэн, гэр бүлийн болон эрүүгийн хэргийг шийдвэрлэх эрх бүхий бусад байгууллага нь эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгаврыг биелүүлэхдээ Хэлэлцэн тохирогч Талуудын энэ зүйлийн 1-д заасан Төв байгууллагаар дамжуулан харилцана.

4 дүгээр зүйл
Эрх зүйн туслалцааны хүрээ

Хэлэлцэн тохирогч Талууд байцаан шийтгэх тодорхой ажиллагаа явуулах замаар даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжид зааснаар тухайлбал, баримт бичиг гардуулан өгөх, нэгжлэг хийх, эд мөрийн баримт хураан авах, шилжүүлэх, шинжилгээ хийх, яллагдагч, гэрч, шинжээч, зохигчид болон бусад этгээдийг байцаах, шүүхийн үзлэг хийх, хохирлыг нөхөн барагдуулахтай холбоотой иргэний болон эрүүгийн хэргийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх, түүнчлэн шийдвэр биелүүлэх замаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэн өгөх, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах, баримт бичиг хүргүүлэх, орчуулах болон мэдээлэл өгөх замаар нэг нь нөгөөдөө эрх зүйн туслалцаа үзүүлнэ.

5 дугаар зүйл
Эрх зүйн туслалцаа үзүүлэх даалгаврын агуулга, хэлбэр

1.Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгаварт дараахь зүйлийг тусгасан байна:

а/даалгавар өгсөн байгууллагын нэр;

б/даалгавар хүлээн авсан байгууллагын нэр;

в/эрх зүйн туслалцаа авахаар хүсэлт тавигдаж байгаа хэргийн нэр;

г/зохигчид, яллагдагч, шүүгдэгч болон даалгаварт хамаарагдах бусад этгээдийн овог, нэр, иргэний харъяалал, эрхэлдэг ажил, оршин суугаа буюу оршин байгаа газар;

д/байцаан шийтгэх ажиллагаанд төлөөлөх хүмүүсийн овог, нэр, хаяг;

е/даалгаврын агуулга, эрүүгийн хэрэгт тухайн хэргийн жинхэнэ байдлын тухай тодорхойлолт, хуулийн зүйлчлэл;

2.Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгавар нь гарын үсэг зурж, даалгавар өгсөн байгууллагын албан ёсны тэмдэг дарсан байна.

3.Хэлэлцэн тохирогч Талууд эрх зүйн туслалцаа үзүүлэхдээ монгол, вьетнам хэлээр үйлдсэн хэвлэмэл хуудас хэрэглэж болох бөгөөд түүний загварыг харилцан солилцоно.

6 дугаар зүйл

Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгавар биелүүлэх журам

1.Даалгавар хүлээн авсан хуулийн байгууллага нь түүнийг биелүүлэхдээ өөрийн улсын хууль тогтоомжийг баримтална. Гэхдээ даалгавар өгсөн байгууллагын хүсэлтээр Хэлэлцэн тохирогч негөө Талын байцаан шийтгэх ажиллагааны хэм хэмжээг өөрийн улсын хууль тогтоомжид харшлахгүй бол хэрэглэж болно.

2.Хэрэв даалгавар хүлээн авсан байгууллага түүнийг биелүүлэх эрх бүхий биш байвал, эрх бүхий байгууллагад шилжүүлж, даалгавар өгсөн байгууллагад хариу мэдэгдэнэ.

3.Хэрэв даалгаварт заасан хаягаар түүнийг биелүүлэх боломжгүй байвал даалгавар хүлээн авсан байгууллага өөрийн хууль тогтоомжийн дагуу хаягийг тогтоох талаар шаардлагатай бүхий л арга хэмжээг авна.

4.Даалгавар хүлээн авсан байгууллага нь түүнийг биелүүлсэн газар, хугацааг даалгавар өгсөн байгууллагын хүсэлтээр өөрт нь болон сонирхогч талуудад цаг тухайд нь мэдэгдэнэ.

5.Хэрэв даалгаврыг биелүүлж чадаагүй бол баримт бичгийг даалгавар өгсөн байгууллагад буцаахын хамт уг даалгаврыг биелүүлэхэд саад болж байгаа шалтгааныг мэдэгдэнэ.

7 дугаар зүйл

Гэрч буюу шинжээчийг дуудах

1.Даалгавар хүлээн авсан байгууллагаас гардуулсан зарлан дуудах хуудасны дагуу даалгавар өгсөн байгууллагад хүрэлцэн ирсэн гэрч буюу шинжээчийг аль улсын харъяат болохыг үл харгалзан даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын хилийг нэвтрэн орохын өмнө үйлдсэн хуулийн зөрчилд холбогдуулан энэ Талын нутаг дэвсгэрт хариуцлагад татах, баривчилах буюу ял шийтгэж болохгүй. Тэдгээр этгээдийг тэдний гаргасан гэрчийн мэдүүлэг буюу шинжээчийн дүгнэлт, эсвэл шалгаж байгаа тухайн эрүүгийн хэрэгт холбогдуулан хариуцлагад татах, баривчлах буюу ял шийтгэж болохгүй.

2.Гэрч буюу шинжээч нь цаашид байх шаардлагагүй гэж мэдэгдсэнээс хойш даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс 15 хоногийн дотор бололцоо байсаар атал гарч явааагүй бол энэ зүйлийн 1-д заасан баталгааг алдана. Дээрх хугацаанд гэрч буюу шинжээчийн өөрөөс нь үл шалтгаалах нөхцөл байдлын улмаас гарч чадаагүй саатсан хугацаа орохгүй.

3.Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт дуудагдаж ирсэн гэрч буюу шинжээч нь байр, зам хоногийн болон уналгын зардал, аваагүй цалингаа нөхөж авах, түүнчлэн шинжээч шинжилгээ хийсний шагналыг авах эрхтэй. Дуудагдсан этгээд ямар зардал авахыг зарлан дуудах хуудаст заасан байх ёстой. Зарлан дуудах хуудас өгсөн Хэлэлцэн тохирогч Талын хуулийн байгууллага гэрч буюу шинжээчийн хүсэлтээр зардлын урьдчилгаа олгоно.

8 дугаар зүйл

Баримт бичиг хүчин төгөлдөр байх

1.Хэлэлцэн тохирогч нэг Талын эрх бүхий байгууллагаас тогтоосон хэлбэрийн дагуу үйлдсэн буюу албан ёсоор гэрчилсэн баримт бичгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт ямар нэгэн нотолгоогүйгээр хүлээн зөвшөөрнө. Энэ нь зохих Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт дагаж мөрдөж байгаа журмын дагуу гарын үсэг нь батлагдсан иргэдийн баримт бичигт нэгэн адил хамаарна.

2.Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт албан ёсны гэж үзсэн баримт бичиг нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт албан ёсны баримт бичгийн нотлох чадвартай байна.

9 дүгээр зүйл

Иргэдийн хувийн эрх, ашиг сонирхолд хамаарах баримт бичиг илгээх

1.Хэлэлцэн тохирогч нэг Тал Хэлэлцэн тохирогч нөгөө Талын дипломат шугамаар ирүүлсэн хүсэлтийн дагуу иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн гэрчилгээ, ажилласан хугацаа, боловсролын тухай болон иргэний хувийн эрх, ашиг сонирхолд хамаарах бусад баримт бичгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талд илгээнэ.

2.Дээр дурдсан баримт бичгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талд орчуулалгүйгээр дипломат шугамаар, үнэ төлбөргүй илгээнэ.

10 дугаар зүйл

Баримт бичгийг гардуулах

1.Гардуулан өгөх баримт бичиг нь даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хэлнээ буюу Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хэлнээ, эсхүл орос хэл дээрхи баталгаат орчуулгатай байвал даалгавар хүлээн авсан байгууллага нь өөрийн улсад дагаж мөрдөж байгаа журмын дагуу түүнийг гардуулна. Бусад тохиолдолд хэрэв хүлээн авагч нь өөрөө зөвшөөрвөл уг баримт бичгийг түүнд шилжүүлэн өгч болно.

2.Баримт бичгийг гардуулан өгөх тухай даалгаварт хүлээн авагчийн тодорхой хаяг, мөн гардуулан өгөх баримт бичгийн нэрийг дурдана.

3.Даалгаварт дурдсан хаягаар уг баримт бичгийг гардуулан өгч чадахгүйд хүрвэл даалгавар хүлээн авсан байгууллага нь өөрийн хууль тогтоомжид заасны дагуу хаягийг тодруулах талаар шаардлагатай арга хэмжээ авна. Хэрэв даалгавар

хүлээн авсан байгууллага нь хаягийг тодруулах боломжгүй бол даалгавар өгсөн байгууллагад энэ тухайгаа мэдэгдэж, гардуулан өгвөл зохих баримт бичгийг буцаан хүргүүлнэ.

11 дүгээр зүйл
Баримт бичгийг гардуулсны баталгаа

Баримт бичгийг гардуулсны баталгааг даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт дагаж мөрдөж байгаа журмын дагуу бүрдүүлнэ. Баримт бичгийг гардуулсны баталгаанд түүнийг гардуулсан газар, хугацааг бичиж, хүлээн авсан хүн гарын үсэг зурсан байна.

12 дугаар зүйл
Дипломат төлөөлөгчийн болон консулын газрын эрх хэмжээ

Хэлэлцэн тохирогч Талууд дипломат төлөөлөгчийн болон консулын газраараа дамжуулан өөрийн иргэнд баримт бичиг гардуулах эрхтэй.

13 дугаар зүйл
Эрх зүйн мэдээлэл өгөх

Хэлэлцэн тохирогч Талуудын Төв байгууллагууд нөгөө Хэлэлцэн тохирогч Талын хүсэлтээр дагаж мөрдөж байсан болон дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, түүнийг хуулийн байгууллагаас хэрэглэж байгаа асуудлаар нэг нь нөгөөдөө харилцан мэдээлэл өгч байна.

14 дүгээр зүйл
Харилцах хэл

Энэхүү Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Хэлэлцэн тохирогч Талууд нэг нь нөгөөдөө гардуулах баримт бичгийг өөрийн хэл дээр үйлдэж, Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эсхүл орос хэл дээрхи орчуулгыг хавсаргасан байна.

15 дугаар зүйл
Эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон зардал

1.Даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал эрх зүйн туслалцаа үзүүлсний зардлыг нөхөн төлөхийг шаардахгүй. Өөрийн нутаг дэвсгэрт эрх зүйн

туслалцаа үзүүлэхтэй холбогдсон бүх зардлыг Хэлэлцэн тохирогч хоёр Тал өөрсдөө хариуцаж байна.

2.Даалгавар хүлээн авсан хуулийн байгууллага нь даалгавар өгсөн хуулийн байгууллагадаа гарсан зардлын хэмжээг мэдэгдэж байна. Хэрэв даалгавар өгсөн хуулийн байгууллага уг зардлыг төлөх үүрэг бүхий этгээдээс гаргуулж авбал тэр нь зардлыг гаргуулан авсан Хэлэлцэн тохирогч Талын орлого болно.

3. Хэрэв даалгаврыг бүрэн биелүүлэх явцад маш их зардал шаардагдахаар бол Төв байгууллагууд даалгаврын зохистой эсэхийг тодорхойлох болон цаашид хэрэгжүүлэх нөхцөлийн талаар харилцан зөвлөлдөнө.

16 дугаар зүйл

Эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах

Хэрэв эрх зүйн туслалцаа үзүүлэх нь Хүсэлт хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын тусгаар тогтнол, аюулгүй байдалд хохирол учруулахаар буюу хууль тогтоомжийн үндсэн зарчимд харшлахаар байвал эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

ИРГЭН, ГЭР БҮЛИЙН ХЭРГИЙН ТАЛААРХИ ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА БОЛОН ХАРИЛЦАА

17 дугаар зүйл

Шүүхийн зардал төлөхөөс чөлөөлөх

Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүхийн ажиллагаанд оролцож байгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнд гадаадын харъяат буюу тухайн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт оршин суудаггүй гэсэн онцгой үндэслэлээр шүүхийн зардал төлөх үүрэг оногдуулж болохгүй.

Байцаан шийтгэх ажиллагааны хөнгөлөлт

18 дугаар зүйл

1.Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт хэргийг хянан хэлэлцэхтэй холбогдож гарсан шүүхийн зардал, хураамжаас чөлөөлөгдөнө. Түүнчлэн хууль зүйн үнэ төлбөргүй туслалцааг Хэлэлцэн тохирогч тухайн Талын иргэдийн нэгэн адил нөхцөл хэмжээгээр авна.

2.Энэ зүйлийн 1-д заасан хөнгөлөлт нь шийдвэрийг биелүүлэх ажиллагааг оролцуулаад тухайн хэргийн талаар явуулж байгаа байцаан шийтгэх бүх ажиллагаанд нэгэн адил хамаарна.

19 дүгээр зүйл

1.Энэ Гэрээний 18 дугаар зүйлд дурдсан хөнгөлөлтийг хүсэлт гаргагчийн хувийн, гэр бүлийн болон эд хөрөнгийн байдлын тухай баримт бичгийг үндэслэн эдлүүлнэ. Уг баримт бичгийн хүсэлт гаргагчийн оршин суугаа буюу оршин байгаа газрын Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага олгоно.

2.Хэрэв хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч хоёр Талын аль алины нь нутаг дэвсгэрт оршин суудаггүй буюу оршин байдаггүй бол өөрийн харъяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газраас олгосон баримт бичгийг үндэслэнэ.

20 дугаар зүйл

1.Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн нь Хэлэлцэн тохирогч негөө Талын нутаг дэвсгэр дээр энэ Гэрээний 18 дугаар зүйлд заасан хөнгөлөлт эдлэх тухай хүсэлтээ өөрийн улсын эрх бүхий байгууллагаар дамжуулан тавьж болно. Уг хүсэлт хүлээн авсан байгууллага нь гаргасан хүсэлтийг нь энэ Гэрээний 19 дүгээр зүйлд дурдсан баримт бичиг болон хүсэлт гаргасан этгээдийн гардуулан өгсөн бусад баримт бичгийн хамт Хэлэлцэн тохирогч негөө Талын эрх бүхий байгууллагад илгээнэ.

2.Энэ Гэрээний 18 дугаар зүйлд заасан хөнгөлөлт эдлэх тухай хүсэлтийн хамт хэрэг үүсгэх тухай өргөдөл болон төлөөлөгч томилох тухай хүсэлт хүргүүлж болно.

3.Хөнгөлөлт эдлэх тухай хүсэлтийг шийдвэрлэх байгууллага нь баримт бичиг олгосон байгууллагаас нэмэгдэл баримт бичиг буюу тайлбар өгөхийг шаардаж болно.

21 дүгээр зүйл

Зохигчид болон эрх зүйн маргаан нь адил хэргийн байцаан шийтгэх ажиллагааг Хэлэлцэн тохирогч хоёр Талын эрх бүхий шүүхүүд үүсгэсэн тохиолдолд энэ гэрээнд өөрөөр заагаагүй бол Хэлэлцэн тохирогч зохих Талын хууль тогтоомжийн дагуу сүүлд хэрэг үүсгэсэн шүүх нь байцаан шийтгэх ажиллагааг зогсоож, энэ тухай негөө Хэлэлцэн тохирогч Талд мэдэгдэнэ.

Хувийн эрхийн байдал

22 дугаар зүйл
Эрхийн чадвар болон эрх олох, үүрэг бий болгох чадвар

1.Эрх олох, үүрэг бий болгох чадварыг уг иргэн харъяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

2.Ахуй амьдралын жижиг хэлцэл хийхтэй холбогдсон эрх олох, үүрэг бий болгох чадварыг уг хэлцлийг нутаг дэвсгэр дээр нь хийж байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

3.Хуулийн этгээдийн эрхийн чадвар болон эрх олох, үүрэг бий болгох чадварыг уг хуулийн этгээдийг байгуулсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

23 дугаар зүйл
Сураггүй алга болсон, нас барсанд тооцох буюу нас барсан үйл баримтыг тогтоох

1.Иргэнийг сураггүй алга болсон буюу нас барсанд тооцох, түүнчлэн нас барсан үйл баримтыг тогтоох тухай хэргийг сүүлчийн мэдээ баримтаар уг иргэн амьд ахуй цагтаа харъяат нь байсан Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ.

2. Хэлэлцэн тохирогч нэг Талын хуулийн байгууллага, Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнийг сураггүй алга болсон буюу нас барсныг зарлах, түүнчлэн нас барсан үйл баримтыг тогтоох асуудлыг өөрийн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа бөгөөд эрх, ашиг сонирхол нь Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжид үндэслэсэн этгээдийн хүсэлтээр шийдвэрлэж болно.

3.Энэ зүйлийн 1, 2-т заасан тохиолдолд Хэлэлцэн тохирогч Талууд байгууллага нь өөрийн улсын хууль тогтоомжийг хэрэглэнэ.

Гэр бүлийн хэрэг

24 дүгээр зүйл
Гэрлэх

1.Гэрлэгсдийн хэн нэг нь Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн, нөгөө нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэн байвал гэрлэх нөхцөлийг гэрлэгч тус бүр харъяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно. Үүнээс гадна гэрлэхэд харшлах зүйлийн хувьд нутаг дэвсгэрт нь гэрлэж байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн шаардлагыг сахих ёстой.

2.Гэрлэх хэлбэрийг нутаг дэвсгэрт нь гэрлэж байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

25 дугаар зүйл

Гэрлэгсдийн хувийн болон эд хөрөнгийн эрхийн харилцаа

1.Гэрлэгсдийн хувийн болон эд хөрөнгийн эрхийн харилцааг тэдний байнга оршин суугаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор зохицуулна.

2.Хэрэв эхнэр, нөхрийн хэн нэг нь Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт оршин суудаг бөгөөд хоёулаа нэг улсын харъяат бол тэдний хувийн болон эд хөрөнгийн эрхийн харилцааг харъяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор зохицуулна.

3.Хэрэв эхнэр, нөхрийн хэн нэг нь Хэлэлцэн тохирогч нэг Талын харъяат, нөгөө нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын харъяат бөгөөд нэг нь Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт, нөгөө нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суудаг бол тэдний хувийн болон эд хөрөнгийн эрхийн харилцааг тэд хамгийн сүүлд хамт оршин сууж байсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор зохицуулна.

4.Хэрэв гэрлэгсэд энэ зүйлийн 3-т зааснаар хамт оршин сууж байгаагүй бол шүүхэд нь нэхэмжлэл гаргасан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримтална.

5.Гэрлэгсдийн хувийн болон эд хөрөнгийн эрхийн харилцааны асуудлыг энэ зүйлийн 1, 2, 3-т заасны дагуу хууль тогтоомжийг нь баримтлах Хэлэлцэн тохирогч Талын байгууллага шийдвэрлэх эрх бүхий байна. Харин 4-т заасан тохиолдолд Хэлэлцэн тохирогч хоёр Талын шүүх эрх бүхий байна.

26 дугаар зүйл

Гэрлэлтийг цуцлах

1.Гэрлэлтийг цуцлахдаа энэ тухай ергөдөл гаргах үед гэрлэгсэд харъяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримтална.

2.Хэрэв эхнэр, нөхрийн хэн нэг нь Хэлэлцэн тохирогч нэг Талын харъяат, нөгөө нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын харъяат бол эрх бүхий байгууллагад нь ергөдөл гаргасан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримтална.

3.Энэ зүйлийн 1-д заасан тохиолдолд ергөдөл гаргах үед гэрлэгсэд харъяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага шийдвэрлэх эрх бүхий байна. Хэрэв гэрлэгсэд ергөдөл гаргах үед Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суугаа бол Хэлэлцэн тохирогч энэ Талын байгууллага эрх бүхий байна.

4.Энэ зүйлийн 2-т заасан тохиолдолд гэрлэгсэд хоёулаа нутаг дэвсгэрт нь оршин суугаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага эрх бүхий байна. Хэрэв гэрлэгсдийн нэг нь Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт, нөгөө нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суудаг бол Хэлэлцэн тохирогч хоёр Талын байгууллага эрх бүхий байна.

27 дугаар зүйл

Гэрлэснийг хүчингүйд тооцох

1.Гэрлэснийг хүчингүйд тооцох тухай хэргийн талаар хэрэглэгдэх хууль тогтоомжийг энэ Гэрээний 24 дүгээр зүйлд заасны дагуу тодорхойлно.

2.Гэрлэснийг хүчингүйд тооцох тухай хэргийн талаар эрх бүхий байгууллагыг энэ Гэрээний 26 дугаар зүйлийн 3, 4-т зааснаар тодорхойлно.

28 дугаар зүйл

Эцэг эх, хүүхдийн эрхийн харилцаа

1.Хүүхдийн эцэг тогтоох болон эцгийн асуудлаар маргаантай хэргийн талаар хүүхэд төрөөд харъяат нь болсон Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримтална.

2.Эцэг эх, хүүхдийн эрхийн харилцааг тэд нутаг дэвсгэрт нь хамт оршин суугаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

3.Хэрэв эцэг эх буюу тэдний аль нэг нь Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт, харин хүүхэд нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суудаг бол тэдний хоорондын эрхийн харилцааг хүүхэд нутаг дэвсгэрт нь оршин суугаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

4.Эцэг эхээс нь хүүхдийн тэтгэвэр гаргуулах, мөн насанд хүрсэн хүүхдээс эцэг эхдээ төлөх тэтгэврийн тухай хэргийг шийдвэрлэхдээ тэтгэвэр авахаар хүсэлт гаргасан иргэн нутаг дэвсгэрт нь оршин суугаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримтална.

5.Энэ зүйлийн 1-д заасан эрхийн харилцааны асуудлыг хүүхэд харъяат нь байгаа буюу хүүхэд нутаг дэвсгэрт нь оршин суугаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага шийдвэрлэх эрх бүхий байна. Энэ зүйлийн 2, 3, 4-т заасан тохиолдолд нэхэмжлэгч нутаг дэвсгэрт нь оршин суугаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага эрх бүхий байна.

29 дүгээр зүйл

Хүүхэд үрчлэх

1.Хүүхэд үрчлэн авахад үрчлэн авагч иргэн харъяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримтална.

2.Хэрэв үрчлэгдэж байгаа иргэн харъяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжид зааснаар үрчлэгдэгчийн буюу түүний хууль ёсны төлөөлөгчийн, түүнчлэн эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авах ёстой бол уг зөвшөөрлийг заавал авна.

3.Хэрэв хүүхэд үрчлэн авч байгаа эхнэр, нөхөр хоёрын хэн нэг нь Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн, нөгөө нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэн бол Хэлэлцэн тохирогч хоёр Талын хууль тогтоомжийг баримтална.

4.Хүүхэд үрчлэхтэй холбогдсон асуудлыг үрчлэн авагч иргэн харъяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага шийдвэрлэх эрх бүхий байна. Энэ зүйлийн 3-т заасан тохиолдолд эхнэр, нөхөр нутаг дэвсгэрт нь хамт оршин суугаа буюу оршин байгаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага эрх бүхий байна.

5.Энэ зүйлийн 1, 2, 3, 4 дэх заалт үрчлэлтийг хүчингүй болгоход нэгэн адил хамаарна.

Асран хамгаалах, харгалзан дэмжих

30 дугаар зүйл

1.Хэрэв энэ Гэрээнд өөрөөр заагаагүй бол Хэлэлцэн тохирогч хоёр Талын иргэдэд асран хамгаалах, харгалзан дэмжих шаардлагатай иргэн харъяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага асран хамгаалалт, харгалзан дэмжлэг тогтооно.

2.Асран хамгаалалт, харгалзан дэмжлэг тогтоох, тэдгээрийг хүчингүй болгох нөхцөлийг асран хамгаалах, харгалзан дэмжих шаардлагатай иргэн харъяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

3.Асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон асран хамгаалуулагч, харгалзан дэмжүүлэгчийн хоорондын эрхийн харилцааг энэ Талын Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлох бөгөөд эрх бүхий байгууллага нь асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг томилно.

4.Асран хамгаалах, харгалзан дэмжих үүргийг асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр томилогдсон иргэн харъяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор зохицуулна.

5.Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн асран хамгаалах, харгалзан дэмжих ажлыг хэрэгжүүлэх Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суугаа бол Хэлэлцэн тохирогч энэ Талын иргэнийг асран хамгаалагч буюу харгалзан дэмжигчээр томилж болно.

31 дүгээр зүйл

1.Хэрэв Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суугаа буюу оршин байгаа, эсвэл эд хөрөнгө нь тэнд байгаа Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэнд асран хамгаалагч буюу харгалзан дэмжигч томилох шаардлага гарвал тухайн Хэлэлцэн тохирогч Талын байгууллага нь энэ Гэрээний 30 дугаар зүйлийн 1-д заасан эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

2.Хэлэлцэн тохирогч нөгөө Талын байгууллага нь хойшлуулшгүй тохиолдолд өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу түр зуурын шаардлагатай арга хэмжээ авч болох бөгөөд энэ тухайгаа энэ Гэрээний 30 дугаар зүйлийн 1-д заасан эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэнэ. Ийнхүү авсан арга хэмжээ нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагаас өөр шийдвэр гаргах хүртэл хүчин төгөлдөр байна.

32 дугаар зүйл

1.Асран хамгаалах, харгалзан дэмжих шаардлагатай иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суугаа буюу оршин байгаа тохиолдолд уг иргэн харъяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага тухайн иргэнд асран хамгаалагч, харгалзан дэмжигч томилох, эсхүл түр арга хэмжээ авах тухай

хүсэлтийг нөгөө Талын эрх бүхий байгууллагад гаргаж болно. Хүсэлтийг хүлээн авсан байгууллага нь асран хамгаалах, харгалзан дэмжих болон түр арга хэмжээ авсан тухайгаа хүсэлт тавьсан байгууллагад мэдэгдэнэ.

2.Хэрэв Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэнд асран хамгаалалт, харгалзан дэмжлэг тогтоосон боловч тэр нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суухаар шилжсэн бол асран хамгаалалт, харгалзан дэмжлэг тогтоосон байгууллага нь нөгөө Талын байгууллагад асран хамгаалах, харгалзан дэмжих ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх тухай хүсэлт тавьж болно. Асран хамгаалалт, харгалзан дэмжлэгийг шилжүүлбэл энэ нь даалгавар хүлээн авсан байгууллага асран хамгаалах, харгалзан дэмжих ажлыг өөртөө хүлээн авч, энэ тухайгаа даалгавар өгсөн байгууллагад мэдэгдсэн үеэс хүчин төгөлдөр болно.

3.Асран хамгаалах, харгалзан дэмжих ажлыг хүлээн авсан байгууллага нь өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх боловч асруулагчийн хувийн эрхтэй холбогдсон асуудлаар шийдвэр гаргах эрхгүй.

Өв залгамжлах

33 дугаар зүйл
Өв залгамжлах хэрэгт тэгш эрхийн зарчим

Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа эд хөрөнгийн болон мөн тэрхүү нутаг дэвсгэрт хэрэгжсэн байх ёстой эрхийн гэрээслэл үйлдэх, түүнийг хүчингүй болгох, түүнчлэн эд хөрөнгө буюу эрхийг өвлөх чадварын хувьд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнтэй тэгш эрхтэй байна. Тэдэнд эд хөрөнгө болон эрхийг өөрийн иргэдийн хувьд тогтоогдсон нөхцөлийн дагуу шилжүүлнэ.

34 дүгээр зүйл
Өв залгамжлах эрх

1.Хөдлөх эд хөрөнгө өвлөх эрхийг өвлүүлэгч нас барах үедээ иргэн нь байсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор зохицуулна.

2.Үл хөдлөх эд хөрөнгө өвлөх эрхийг уг эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор зохицуулна.

3.Ямар эд хөрөнгийг хөдлөх, үл хөдлөх гэж үзэх тухай асуудлыг уг эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор шийдвэрлэнэ.

35 дугаар зүйл
Өв залгамжлал улсад шилжих

Хуульд заасны дагуу өвлөгдөх эд хөрөнгө улсад өвлөгдөж байгаа болон Хэлэлцэн тохирогч хоёр Талын хууль тогтоомжийн дагуу улсад шилжвэл хөдлөх эд хөрөнгө өвлүүлэгч нас барах үедээ иргэн нь байсан Хэлэлцэн тохирогч Талын

орлого, харин үл хөдлөх эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын орлого болно.

36 дугаар зүйл
Гэрээслэл

1.Гэрээслэл хийх буюу хүчингүй болгох чадвар, түүнчлэн санаа зоригоо дутуу илэрхийлснээс үүссэн эрх зүйн үр дагаварыг гэрээслэгч гэрээслэл хийх буюу хүчингүй болгох үед харъяат нь байсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

2.Гэрээслэл хийх, түүнийг хүчингүй болгох хэлбэрийг гэрээслэгч гэрээслэл хийх буюу хүчингүй болгох үед харъяат нь байсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно. Гэвч нутаг дэвсгэрт нь гэрээслэл хийсэн буюу хүчингүй болгосон Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримтлахад хангалттай.

37 дугаар зүйл
Өв залгамжлалын хэргийг шийдвэрлэх эрх бүхий байгууллага

1.Хөдлөх эд хөрөнгийг өв залгамжлах тухай хэргийг өвлүүлэгч сүүлийн удаа нутаг дэвсгэрт нь байнга оршин сууж байсан Хэлэлцэн тохирогч Талын хуулийн байгууллага шийдвэрлэх эрх бүхий байна.

2.Үл хөдлөх эд хөрөнгийг өв залгамжлах тухай хэргийг уг эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хуулийн байгууллага шийдвэрлэх эрх бүхий байна.

3.Өв залгамжлах хэргээс үүссэн маргааныг шийдвэрлэхэд энэ зүйлийн 1, 2-т заасныг баримтална.

38 дугаар зүйл
Өв залгамжлалыг хамгаалах арга хэмжээ

1.Хэлэлцэн тохирогч Талуудын байгууллага нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнээс тэдгээрийн нутаг дэвсгэрт нь үлдээсэн өвлөгдөх хөрөнгийн хамгаалалтыг хангах буюу эрхлэн гүйцэтгэх шаардлагатай арга хэмжээг хууль тогтоомжийнхоо дагуу авна.

2.Энэ зүйлийн 1-д заасан арга хэмжээний тухай түүнийг хэрэгжүүлэхэд оролцож болох Хэлэлцэн тохирогч нөгөө Талын дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт нэн даруй мэдэгдэнэ. Энэ зүйлийн 1-д заасны дагуу авсан арга хэмжээг дипломат төлөөлөгчийн буюу консулын газрын хүсэлтээр зогсоож, хойшлуулж, өөрчилж болно.

39 дүгээр зүйл
Гэрээслэлийг шилжүүлэн өгөх

Хэрэв гэрээслэл Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт байгаа бөгөөд өв залгамжлах ажиллагааг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хуулийн байгууллага эрхлэн гүйцэтгэх эрх бүхий байвал гэрээслэлийн баталгаат хуулбарыг, харин хүсвэл жинхэнэ эхийг уг байгууллагад шилжүүлэн өгнө.

Хэлцлийн хэлбэр болон гэм хорыг арилгах

40 дүгээр зүйл
Хэлцлийн хэлбэр

1.Хэлцлийн хэлбэрийг хэлцлийг хэрэгжүүлэх Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлох боловч, нутаг дэвсгэрт нь хэлцэл байгуулсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримталж болно.

2.Үл хөдлөх эд хөрөнгийн хэлцлийн хэлбэрийг уг эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

41 дүгээр зүйл
Гэм хорыг арилгах

2.Гэм хор учруулснаас үүссэн үүргийн талаар хүлээх хариуцлагыг гэм хорыг арилгах тухай шаардлага тавих үндэслэл болсон үйл явдал буюу өөр нөхцөл байдал нутаг дэвсгэрт нь бий болсон Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

2.Гэм хор учруулсан этгээд болон хохирогч нь Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн бол учирсан гэм хорыг арилгахдаа Хэлэлцэн тохирогч энэ Талын хууль тогтоомжийг баримтална.

3.Энэ зүйлийн 1, 2-т заасан асуудлаар шийдвэр гаргахад хууль тогтоомжийг нь баримтлах Хэлэлцэн тохирогч Талын хуулийн байгууллага эрх бүхий байна.

Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх

42 дугаар зүйл
Эд хөрөнгийн бус шинжтэй хэргийн талаарх шийдвэрийг хүлээн зөвшөөрөх

Хэлэлцэн тохирогч нэг Талын хуулийн байгууллага, иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх болон асран хамгаалах, харгалзан дэмжих байгууллагаас

гаргасан иргэний /хөдөлмөрийнхийг оролцуулаад/ болон гэр бүлийн эд хөрөнгийн бус шинжтэй хэргийн талаарх хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэрийг хэрэв энэ Гэрээний 47 дугаар зүйлд зааснаар хүлээн зөвшөөрөхөөс татгалзаагүй бол Хэлэлцэн тохирогч негее Талын нутаг дэвсгэрт байцаан шийтгэх ажиллагаа явуулахгүйгээр хүлээн зөвшөөрнө. Ийм шийдвэрийг энэ Гэрээ хүчин төгөлдөр болохоос емнө гарсан тохиолдолд ч нэгэн адил хүлээн зөвшөөрнө.

43 дугаар зүйл

Эд хөрөнгийн шинжтэй хэргийн талаархи шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх

Энэ Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш Хэлэлцэн тохирогч негее Талын нутаг дэвсгэрт гаргасан буюу хуулийн хүчин төгөлдөр болсон дараахь шийдвэрийг Хэлэлцэн тохирогч Талууд уг гэрээнд заасан нөхцөлөөр харилцан хүлээн зөвшөөрч, биелүүлнэ:

а/иргэний /хөдөлмөрийнхийг оролцуулаад/ болон гэр бүлийн эд хөрөнгийн шинжтэй хэргийн талаарх шүүхийн шийдвэр;

б/ арбитрын шийдвэр;

в/шүүхээс тогтоосон эвлэрэх хэлцэл;

г/таслан шийдвэрлэх тогтоолын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбогдсон хэсэг.

44 дүгээр зүйл

Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай хүсэлт

1.Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай хүсэлтийг уг хэргийн талаар шийдвэр гаргасан хуулийн байгууллагад гаргана. Уг хуулийн байгууллага хүсэлтийг энэ Гэрээний 46 дугаар зүйлд заасны дагуу шийдвэр гаргах эрх бүхий шүүхэд хүргүүлнэ. Хэрэв шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай хүсэлт тавьсан этгээд уг шийдвэрийг биелүүлэх ёстой этгээд Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт оршин суугаа буюу оршин байгаа бол хүсэлтийг Хэлэлцэн тохирогч энэ Талын эрх бүхий шүүхэд шууд гаргаж болно.

2.Хүсэлтэд дурдвал зохих зүйлийг нутаг дэвсгэрт нь шийдвэрийг биелүүлэх Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

45 дугаар зүйл

Хүсэлтэд хавсаргах баримт бичиг

Шийдвэр хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай хүсэлтэд дор дурдсан зүйлийг хавсаргана:

а/хуулийн байгууллагын шийдвэрийн баталгаатай хуулбар, хэрэв шийдвэрт тодорхой заагаагүй бол уг шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсныг нотолсон, түүнийг биелүүлбэл зохих тухай албан ёсны баримт бичиг;

б/байцаан шийтгэх ажиллагаанд оролцоогүй хариуцагч буюу түүний бүрэн эрхт төлөөлөгчид шүүхийн зарлан дуудах хуудсыг цаг тухайд нь зохих ёсоор гардуулсан баримт бичиг;

в/энэ зүйлд заасан баримт бичгийн баталгаатай орчуулга болон хүсэлтийн орчуулга.

46 дугаар зүйл

Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх журам

1.Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай хүсэлтийг шийдвэр нутаг дэвсгэрт нь биелэгдэх ёстой Хэлэлцэн тохирогч Талын шүүх авч хэлэлцэнэ.

2.Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай хүсэлтийг авч хэлэлцэж байгаа шүүх энэ Гэрээнд заасан нөхцөл бүрдсэнийг тогтооно. Нөхцөл бүрдсэн тохиолдолд шүүх шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлнэ.

3.Хэрэв шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай асуудлыг хэлэлцэхэд шүүхэд эргэлзээ төрвөл шийдвэр биелүүлэх тухай хүсэлт тавьсан этгээдээс тайлбар өгөхийг хүсэх, түүнчлэн хүсэлтийн агуулгын талаар хариуцагчийг байцаах болон шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргасан хуулийн байгууллагаас тайлбар гаргаж өгөхийг шаардаж болно.

47 дугаар зүйл

Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхээс татгалзах

Шийдвэрийг хүлээн зөвшөөрөхөөс болон биелүүлэхээс дараахь тохиолдолд татгалзаж болно:

а/хэрэв шүүхийн зарлан дуудах хуудсыг хариуцагч буюу түүний бүрэн эрхт төлөөлөгчид цаг тухайд нь зохих ёсоор гардуулаагүйн улмаас хариуцагч байцаан шийтгэх ажиллагаанд оролцоогүй бол;

б/хэрэв нутаг дэвсгэрт нь шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх ёстой Хэлэлцэн тохирогч Талын байгууллагаас тухайн зохигчдын хооронд нэгэн асуудал болон үндэслэлээр хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэр урьд гаргасан буюу Хэлэлцэн тохирогч энэ Талын байгууллага уг хэргийн талаар байцаан шийтгэх ажиллагааг явуулж эхэлсэн бол;

в/хэрэв энэ Гэрээнд заасны дагуу болон заагаагүй боловч тухайн хэрэг нь энэ Гэрээний болон нутаг дэвсгэрт нь шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх ёстой Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу Хэлэлцэн тохирогч энэ Талын байгууллагын онцгой эрх мэдэлд хамаарч байгаа бол.

48 дугаар зүйл

Шийдвэрийг биелүүлэх

1.Шийдвэрийг биелүүлэх журмыг шийдвэр нутаг дэвсгэрт нь биелэгдэх ёстой Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

2.Хэлэлцэн тохирогч Талын хуулийн байгууллагын шийдвэрийг хэрэв хууль тогтоомжид заасан байвал хариуцагч биелүүлэхээс татгалзаж болно.

3.Шийдвэрийг биелүүлэхтэй холбогдсон шүүхийн зардлын хувьд шийдвэр нутаг дэвсгэрт нь биелэгдэх ёстой Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг баримтална.

Шүүхийн зардлын тухай шийдвэрийг биелүүлэх

49 дүгээр зүйл

1.Хэрэв энэ Гэрээний 17 дугаар зүйлийн дагуу шүүхийн зардал төлөхөөс чөлөөлөгдсөн иргэнд Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт шүүхийн зардал төлөх үүрэг оногдуулсан бол Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа зохих шүүх тухайн зардлыг уг хүнээс гаргуулах асуудлыг хүсэлтийн дагуу үнэ төлбөргүйгээр шийдвэрлэнэ.

2.Шүүхийн зардлаас гадна энэ Гэрээний 45 дугаар зүйлд дурдсан баримт бичгийг орчуулсны буюу гэрчилсний зардлыг мөн гаргуулна.

50 дугаар зүйл

1.Шүүхийн зардал гаргуулах шийдвэр биелүүлэхийг зөвшөөрөх тухай хүсэлтэд уг зардлын талаархи шийдвэрийн баталгаатай хуулбар, шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон бөгөөд түүнийг биелүүлбэл зохих тухай магадлагааг хавсаргана.

2.Дурдсан баримт бичгийг шийдвэр нутаг дэвсгэрт нь биелэгдэх ёстой Хэлэлцэн тохирогч Талын хэлээр буюу орос хэлээр орчуулсан байна.

3.Шүүхийн зардал гаргуулах шийдвэр биелүүлэхийг зөвшөөрч байгаа шүүх зөвхөн дор дурдсан зүйлийг шалгаж үзнэ:

а/шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон эсэх, түүнийг биелүүлэх ёстой эсэх;

б/энэ зүйлийн 1-д дурдсан баримт бичгийн баталгаатай орчуулга байгаа эсэх.

4.Биелүүлэхийг зөвшөөрсөн тухай шүүхийн шийдвэрийг шүүхээс нь уг шийдвэрийг гаргасан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу давж заалдаж болно.

51 дүгээр зүйл

Шүүхийн зардлын талаарх шийдвэрийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт биелүүлэхийг зөвшөөрөх тухай хүсэлтийг Хэлэлцэн тохирогч энэ Талын эрх бүхий шүүхэд буюу зардлын талаарх шийдвэр гаргасан шүүхэд тавина. Зардлын талаар шийдвэр гаргасан шүүх уг хүсэлтийг энэ Гэрээний 50 дугаар зүйлд дурдсан баримт бичгийн хамт Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий шүүхэд хүргүүлнэ.

52 дугаар зүйл

1.Шүүх нь зохигчдын саналыг авахгүйгээр шүүхийн зардлын тухай шийдвэрийг биелүүлэхийг зөвшөөрнө.

2.Хүсэлт гаргасан этгээд шийдвэр биелүүлэхтэй холбогдсон зардлыг урьдчилан төлөөгүй гэсэн үндэслэлээр шүүхийн зардлын тухай шийдвэрийг биелүүлэхээс татгалзаж болохгүй.

53 дугаар зүйл
Эд зүйл гаргах болон мөнгө гуйвуулах

Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрээс Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт энэ Гэрээний дагуу эд зүйл гаргах болон мөнгө гуйвуулахад нутаг дэвсгэрээс нь эд зүйл гаргах буюу мөнгө гуйвуулах Талын хууль тогтоомжийг баримтална.

ГУРАВДУГААР ХЭСЭГ

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА

54 дүгээр зүйл
Шилжүүлэн өгөх үүрэг

1.Хэлэлцэн тохирогч Талууд энэ Гэрээнд заасан нэхцэлийн дагуу өөрийн нутаг дэвсгэрт байгаа этгээдийг эрүүгийн хариуцлагад татах буюу таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхийн тулд бие биенийхээ шаардлагын дагуу шилжүүлэн өгөх үүрэг хүлээнэ.

2.Хэлэлцэн тохирогч Талуудын хууль тогтоомжид зааснаар гэмт хэрэг гэж үзэх хэрэг үйлдсэн бөгөөд тэр хэрэгт нь нэг жилээс дээш хугацаагаар хорих буюу

өөр хүнд ял оногдуулах зөвхөн тийм нөхцөлд эрүүгийн хариуцлагад татахаар шилжүүлэн өгч болно.

Зургаан сараас дээш хугацаагаар хорих буюу өөр хүнд ял шийтгэл оногдуулах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдийг ял шийтгэсэн бөгөөд хуулийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхээр шилжүүлэн өгч болно.

55 дугаар зүйл

Шилжүүлэн өгөхөөс татгалзах

1.Шилжүүлэн өгөхөөс дор дурдсан тохиолдолд татгалзана:

а/гэмт хэрэг үйлдсэн этгээд нь шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын иргэн бол;

б/шаардлага хүлээж авах үед шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжид зааснаар хөөн хэлэлцэх хугацаа дууссан, өршөөл үзүүлсэн буюу хууль зүйн бусад үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэж, эсвэл таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлж болохгүй болсон;

в/шилжүүлэн өгөхийг шаардсан этгээдийн хувьд шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт тухайн гэмт хэргийн талаар хуулийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоол гарсан буюу хэргийг хэрэгсэхгүй болгосон;

г/Хэлэлцэн тохирогч хоёр Талын хууль тогтоомжийн дагуу эрүүгийн хэргийн байцаан шийтгэх ажиллагааг хохирогчийн гомдлоор үүсгэсэн бол;

2.Шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт үйлдсэн хэрэгтэй холбогдуулан шилжүүлэн өгөхийг шаардаж байгаа бол шилжүүлэн өгөхөөс татгалзаж болно.

3.Шилжүүлэн өгөхөөс татгалзсан тохиолдолд татгалзаж байгаа үндэслэлээ шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талд мэдэгдэнэ.

56 дугаар зүйл

Шилжүүлэн өгөх тухай шаардлага

1.Шилжүүлэн өгөх тухай шаардлагад дор дурдсан зүйлийг тусгасан байна. Үүнд:

а/шаардлага тавьсан байгууллагын нэр;

б/шаардлага тавьсан Хэлэлцэн тохирогч Талын хуулиар тухайн хэргийг гэмт хэрэг гэж тодорхойлсон заалт;

в/шилжүүлэн өгөх этгээдийн овог, нэр, иргэний харъяалал, оршин суугаа буюу оршин байгаа газрын хаяг, фото зураг, бололцоотой бол түүний гадаад төрх байдлын тодорхойлолт, хувийн байдлын тухай бусад мэдээ;

г/хэрэв гэмт хэргийн улмаас хохирол учирсан бол хохирлын хэмжээний тухай мэдээ.

2.Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахаар шилжүүлэн өгөх тухай шаардлагад хэргийн бодит нөхцөл байдлын тухай тодорхойлолт, баривчлах тогтоолын баталгаатай хуулбарыг хавсаргасан байх ёстой.

3.Таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхээр шилжүүлэн өгөх тухай шаардлагад шүүхийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолын

баталгаатай хуулбар болон уг этгээдийг ял шийтгэх үндэслэл болсон хуулийн заалтыг хавсаргана. Хэрэв ялтан ялынхаа зарим хэсгийг эдэлсэн бол энэ тухай нэгэн адил мэдэгдэнэ.

57 дугаар зүйл
Шилжүүлэн өгөхөөр цагдан хорих

Шилжүүлэн өгөх тухай шаардлага хүлээн авмагц түүнийг хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал шилжүүлэн өгч болохгүй гэж энэ Гэрээнд зааснаас бусад тохиолдолд шилжүүлэн өгвөл зохих этгээдийг цагдан хорих арга хэмжээг нэн даруй авна.

58 дугаар зүйл
Нэмэлт мэдээ

1.Шилжүүлэн өгөх тухай шаардлагад холбогдох бүх мэдээ баримт тусгагдаагүй бол шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал нэмэгдэл мэдээ шаардаж болох бөгөөд үүний тулд 2 сар хүртэл хугацаа тогтоож өгнө. Хүндэтгэн үзэх шалтгаантай бол энэ хугацааг шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талын хүсэлтээр сунгаж болох боловч 2 сараас хэтрэхгүй.

2.Хэрэв тогтоосон буюу сунгасан хугацаанд энэ зүйлийн 1-д заасан нэмэгдэл мэдээг авч чадаагүй бол шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага шилжүүлэн өгөх ажиллагааг зогсоож цагдан хоригдсон этгээдийг суллаж болно.

59 дүгээр зүйл
Шилжүүлэн өгөх тухай шаардлагыг хүлээн авахын өмнө цагдан хорих

1.Шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал нь түүнийг өгсөн Хэлэлцэн тохирогч Талын хүсэлтээр хойшлуулашгүй тохиолдолд энэ Гэрээний 56 дугаар зүйлд заасны дагуу шилжүүлэн өгөх тухай шаардлага ирэхээс өмнө зохих этгээдийг цагдан хорьж болно. Уг хүсэлтэд шилжүүлэн өгөх этгээдийг цагдан хорих тухай тогтоол буюу хуулийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолыг иш үндэс болгон, шилжүүлэн өгөх шаардлага нэн даруй явуулна гэдгийг заасан байх ёстой. Хүсэлтийг шуудан, цахилгаан, телефон буюу бусад аргаар тавьж болно.

2.Хэрэв тухайн этгээд шилжүүлэн өгвөл зохих гэмт хэргийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт үйлдсэн гэдэг лавтай үндэслэл байвал Хэлэлцэн тохирогч аль ч Талын эрх бүхий байгууллага нь өөрийн нутаг дэвсгэрт байгаа этгээдийг энэ зүйлийн 1-д заасан шаардлагыг хүлээлгүйгээр түр цагдан хорьж болно.

3.Энэ зүйлийн 1, 2-т зааснаар цагдан хорьсон тухай Хэлэлцэн тохирогч нөгөө Талд нэн даруй мэдэгдэж байна.

60 дугаар зүйл

Түр цагдан хоригдсон этгээдийг суллах

Энэ Гэрээний 59 дүгээр зүйлд зааснаар цагдан хорьсон этгээдийг энэ тухай мэдээ явуулсан өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд Хэлэлцэн тохирогч нөгөө Талаас шилжүүлэн өгөх тухай шаардлага ирээгүй бол цагдан хоригдсон этгээдийг суллах ёстой. Уг цагдан хоригдсон этгээдийг сулласан тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талд мэдэгдэнэ.

61 дүгээр зүйл

Шилжүүлэн өгөхийг хойшлуулах

Шилжүүлэн өгвөл зохих этгээд шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт эрүүгийн хариуцлагад татагдсан буюу өөр хэргийн учир ял эдэлж байгаа бол эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж дуусгах, оногдуулсан ялыг эдэлж дуусах буюу хугацаанаас нь өмнө суллах хүртэл шилжүүлэн өгөхийг хойшлуулж болно.

62 дугаар зүйл

Түр шилжүүлэн өгөх

1.Энэ Гэрээний 61 дүгээр зүйлд зааснаар шилжүүлэн өгөхийг хойшлуулах нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хөөн хэлэлцэх хугацаа дуусахаар буюу гэмт хэргийг байцаан шалгах ажиллагаанд ноцтой бэрхшээл учруулахаар байвал шилжүүлэн өгвөл зохих этгээдийг үндэслэл бүхий хүсэлтээр түр шилжүүлэн өгч болно.

2.Эрүүгийн хэргийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахаар түр шилжүүлэн өгсөн этгээдийг уг ажиллагааг явуулж дуусмагц нэн даруй буцаах ёстой.

63 дугаар зүйл

Хэд хэдэн улсын тавьсан шаардлагыг шийдвэрлэх

Хэрэв нэг этгээдийг шилжүүлэн өгөх тухай шаардлага хэд хэдэн улсаас гаргавал уг шаардлагын алиныг нь биелүүлэхээ шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал шийдвэрлэнэ.

64 дүгээр зүйл

Шилжүүлэн өгсөн этгээдийг байцаан шийтгэх хязгаар

1.Шилжүүлэн өгсөн этгээдийг шилжүүлэн өгөхөөс өмнө үйлдсэн хэрэгтэй нь холбогдуулан шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татаж, ял шийтгэж болохгүй.

2.Түүнчлэн шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын зөвшөөрөлгүйгээр гуравдахь улсад шилжүүлэн өгч болохгүй.

3.Шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын зөвшөөрлийг дор дурдсан тохиолдолд авахгүй:

а/шилжүүлэн өгсөн этгээд нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа дууссан, ял эдэлж дууссан буюу хугацаанаас нь өмнө суллагдсан үеэс хойш нэг сарын дотор шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс бололцоо байсаар атал гарч яваагүй бол. /Уг хугацаанд шилжүүлэн өгсөн этгээд өөрөөсөө үл шалтгаалах нөхцөл байдлын улмаас шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс явж чадаагүй байсан хугацааг уг хугацаанд оруулахгүй / ;

б/шилжүүлэн өгсөн этгээд шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрээс яваад сайн дураараа нутаг дэвсгэрт нь эргэж ирсэн бол.

65 дугаар зүйл

Шилжүүлэн өгөх ажиллагаа

1.Шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал шилжүүлэн өгөх газар, цаг хугацааг шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талд мэдэгдэнэ.

2.Шилжүүлэн өгөх этгээдийг шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Тал нь шилжүүлэн өгөхөөр тогтоосон хугацаанаас хойш 15 хоногийн дотор хүлээж аваагүй цагдан хоригдсон этгээдийг суллана. Хэлэлцэн тохирогч Талуудын тохирсноор уг хугацааг 15 хүртэл хоногоос хэтрүүлэхгүйгээр сунгаж болно.

66 дугаар зүйл

Дахин шилжүүлэн өгөх

Шилжүүлэн өгсөн этгээд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанаас буюу ял эдлэхээс зайлсхийж шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт буцаж ирвэл шаардлага өгсөн Хэлэлцэн тохирогч Талын шинэ шаардлагын дагуу энэ Гэрээний 56 дугаар зүйлд дурдсан мэдээ, материал гаргуулахгүйгээр уг этгээдийг дахин шилжүүлж өгөх ёстой.

67 дугаар зүйл

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны дүнгийн тухай мэдээлэх

Шилжүүлэн өгсөн этгээдийг хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал нь эрүүгийн хэргийн байцаан шийтгэх ажиллагааны дүнг шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талд мэдээлнэ. Хүсэлт гарсан тохиолдолд эцсийн шийдвэрийн хуулбарыг хүргүүлнэ.

68 дугаар зүйл

Дамжуулан өнгөрүүлэх

1.Хэлэлцэн тохирогч нэг Тал Хэлэлцэн тохирогч негее Талын хүсэлтээр гуравдахь улсаас Хэлэлцэн тохирогч негее Талд шилжүүлэн өгөх этгээдийг өөрийн нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэхийг зөвшөөрнө. Хэлэлцэн тохирогч Талууд энэ Гэрээнд шилжүүлэн өгч болохгүй гэж заасан этгээдийг дамжуулан өнгөрүүлэхийг зөвшөөрөх ёсгүй.

2.Дамжуулан өнгөрүүлэх тухай хүсэлтийг шилжүүлэн өгөх тухай шаардлагын адил журмаар үйлдэж, хүргүүлнэ.

69 дүгээр зүйл

Шилжүүлэн өгөх болон дамжуулан өнгөрүүлэх зардал

Шилжүүлэн өгөх зардлыг уг зардал нутаг дэвсгэрт нь гарсан Хэлэлцэн тохирогч Тал хариуцна. Харин дамжуулан өнгөрүүлэхтэй холбогдсон зардлыг даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Тал хариуцна.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг явуулах

70 дугаар зүйл

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах үүрэг

1.Хэлэлцэн тохирогч Тал бүр даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдэж байгаа өөрийн улсын иргэний талаар хууль тогтоомжийнхоо дагуу Хэлэлцэн тохирогч негее Талын шаардлагаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах үүргийг хүлээнэ.

2.Хэлэлцэн тохирогч нэг Талын эрх бүхий байгууллагад хууль тогтоомжид заасан хугацааны дотор өгсөн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай хохирогчийн хүсэлт нь Хэлэлцэн тохирогч негее Талын нутаг дэвсгэрт нэг адил хүчинтэй байна.

3.Гэмт хэргийн улмаас хохирсон этгээд хохирлыг нехен төлүүлэх тухай шаардлага тавьсан бол энэ тухай байцаан шийтгэх ажиллагаа явуулах даалгавар өгч, хохирсон этгээдийг уг хэрэгт оролцуулна.

71 дүгээр зүйл

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай даалгавар

1.Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай даалгаварт дор дурдсан зүйлийг тусгасан байна:

а/даалгавар өгсөн байгууллагын нэр;

б/эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай даалгавар өгөх болсон хэргийн тодорхойлолт;

в/хэргийг үйлдсэн цаг хугацаа, газрын тухай аль болох нарийн заасан мэдээ баримт;

г/хэргийг гэмт хэрэг гэж үзэх үндэслэл болж байгаа даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын хуулийн заалт, түүнчлэн хэргийн талаар байцаан шийтгэх ажиллагаа явуулахад чухал ач холбогдол бүхий хууль тогтоомжийн бусад актын заалт;

д/сэжигтний овог, нэр, түүний иргэний харъяалал, оршин суугаа буюу оршин байгаа газрын хаяг, хувийн байдлын тухай бусад мэдээ;

е/хохирогчийн гомдлоор үүсгэдэг эрүүгийн хэргийн хувьд хохирогчийн гомдол болон хохирлыг нөхөн төлүүлэх тухай өргөдөл;

ж/хэрэв гэмт хэргийн улмаас хохирол учирсан бол хохирлын хэмжээний тухай мэдээ.

Даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын мэдэлд байгаа эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны материал болон нотлох баримтыг даалгаварт хавсаргана.

2.Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай даалгаврыг шилжүүлэн өгөх үед яллагдагч даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт цагдан хоригдож байсан бол түүнийг даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талд шилжүүлнэ.

3.Даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал эцсийн шийдвэрээ даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талд мэдэгдэнэ. Эцсийн шийдвэрийн хуулбарыг даалгавар өгсөн хэлэлцэн тохирогч Талын хүсэлтээр хүргүүлнэ.

72 дугаар зүйл

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулсны үр дагавар

Хэлэлцэн тохирогч Талд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тухай даалгаврыг энэ Гэрээний 70 дугаар зүйлд заасны дагуу хүргүүлсэн бөгөөд таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон буюу эцсийн өөр шийдвэрийг даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын байгууллага гаргасан бол даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын байгууллага эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгоно.

Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх бусад асуудал

73 дугаар зүйл
Гэмт хэрэгтэй холбогдсон эд зүйлийг шилжүүлэх

1.Хэлэлцэн тохирогч Талууд бие биедээ гаргасан хүсэлтийн дагуу гэмт хэргийн зэвсэг, хэргийн ул мөр бүхий эсхүл гэмт хэргийн замаар олсон бүхий л эд зүйлийг гэмт этгээдтэй аль болох хамт шилжүүлнэ.

2. Гэмт этгээд нас барсан эсхүл өөр нөхцөл байдлын улмаас түүнийг шилжүүлэн өгөх боломжгүй тохиолдолд ч гэсэн энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд зүйлийг шилжүүлнэ.

3.Даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талд шилжүүлэн өгсөн эд зүйлийн хувьд гуравдахь этгээдийн эдлэх эрх халдашгүй хэвээр үлдэнэ. Байцаан шийтгэх ажиллагаа дууссаны дараа эдгээр эд зүйлийг шилжүүлэн өгсөн Хэлэлцэн тохирогч Талд үнэ төлбөргүй эргүүлэн өгөх ёстой. Зарим тохиолдолд хэрэв байцаан шийтгэх ажиллагаа явуулахад харшлахгүй бол эдгээр эд зүйлийг байцаан шийтгэх ажиллагааг явуулж дуусахаас өмнө уг эд зүйлийг эзэмших эрх бүхий этгээдэд нь эргүүлэн өгч болно.

Хэрэв уг эд зүйлийг эзэмших эрх бүхий этгээд даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт оршин суудаг бол Хэлэлцэн тохирогч энэ Тал даалгавар хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын зөвшөөрлийн үндсэн дээр эд зүйлийг тухайн этгээдэд шууд шилжүүлэн өгөх эрхтэй.

74 дүгээр зүйл
Таслан шийдвэрлэх тогтоолын болон ял шийтгэгдсэн эсэх тухай мэдэгдэх

1.Хэлэлцэн тохирогч Талууд Хэлэлцэн тохирогч нэг Талын шүүхээс Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэний тухай гаргасан таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон тухай мэдээг жил бүр бие биедээ мэдээлж байна.

2.Хэлэлцэн тохирогч Талуудын шүүхээр урьд нь ял шийтгүүлж байсан этгээд даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт эрүүгийн хариуцлагад татагдаж байгаа бол түүний ял шийтгэгдэж байсан тухай мэдээг Хэлэлцэн тохирогч Талууд нэг нэгэндээ хүсэлтээр нь өгнө.

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ

ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

75 дугаар зүйл
Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

Энэхүү Гэрээнд Хэлэлцэн тохирогч Талууд харилцан зөвшөөрөлцсөнөөр нэмэлт, өөрчлөлт оруулах бөгөөд Хэлэлцэн тохирогч Тал бүр үндэсний хууль тогтоомжийн дагуу хууль зүйн бүхий л журмыг биелүүлсний дараа уг нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болно.

76 дугаар зүйл
Гэрээ хүчин төгөлдөр болох

Энэхүү Гэрээг соёрхон батлах бөгөөд Батламж жуух бичгийг ..... солилцсон өдрөөс эхлэн 30 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

77 дугаар зүйл
Гэрээ дуусгавар болох

Энэхүү Гэрээ хугацаагүй бөгөөд Хэлэлцэн тохирогч аль нэг Тал дипломат шугамаар Гэрээг цуцлах тухайгаа бичгээр мэдэгдсэн өдрөөс хойш 6 сар өнгөрөгц энэхүү Гэрээний үйлчлэх хугацаа дуусгавар болно.

2000 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр Улаанбаатар хотод монгол, вьетнам, орос хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

Энэхүү Гэрээг тайлбарлах явцад маргаан гарвал Хэлэлцэн тохирогч Талууд орос хэл дээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

БҮГД НАЙРАМДАХ СОЦИАЛИСТ ВЬЕТНАМ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС